

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө	7
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт	7
2.8.3 Авлага.....	7
2.8.4 Урьдчилгаа	8
2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт	8
2.8.6 Бараа материал	8
2.8.7 Үндсэн хөрөнгө	9
2.8.8 Өр төлбөр	9
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	10
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	12
2.11. Шилэн дансны мэдээлэл	12
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	12
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
3. Менежментийн захидал.....	13
3.1 Гадаад сургалттай холбоотой асуудал.....	13
3.2 Бараа материалтай холбоотой асуудал	13
3.3 Шилэн данстай холбоотой асуудал.....	14
3.4 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар.....	14
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	15
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	16
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СС	Сангийн сайд
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

202003.25 № 01/950
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Иргэний нисэхийн ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль, тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Иргэний нисэхийн ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

- Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 13,880.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээр тогтоосон материаллаг байдлын түвшнээс 7,424.1 сая төгрөгөөр давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг, тохиолдсон байх, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Иргэний нисэхийн ерөнхий газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



2. Аудитын тайлан

2.1 Оршил

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Л.Бямбасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг үнэн зөв бэлтгэх, гадаад сургалтын журмын дагуу суралцуулахтай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 20-ноос 2020 оны 4 дүгээр сарын 1-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Р.Цолмон, гэрээт аудитор Б.Мөнгөнцэцэг нар гүйцэтгэв.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 01/490 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Иргэний нисэхийн ерөнхий газрын дотоод аудитын алба 2019 онд харьяа орон нутаг дахь 26 алба, нэгжид төлөвлөгөөт шалгалтыг 22, төлөвлөгөөт бус шалгалтыг 9, нийт 31 дотоод аудит, хяналт шалгалтыг хийсэн байна.

Дээрх дотоод аудит, хяналт шалгалтаар нийт 1,180.0 сая төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг засч залруулах 263 зөвлөмж өгч, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьсан байна. Тус албанаас гаргасан үнэлгээгээр зөвлөмжийн хэрэгжилт 92.2 хувьтай байна.

2.5 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Иргэний нисэхийн ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг нийт орлогын 371,207.1 сая төгрөгийн 2 хувь буюу 7,424.1 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

2.7 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 1 төсвийн байгууллага, 23 төрийн өмчит аж ахуйн нэгж, нийт 24 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 14 байгууллага аудитад хамрагдсан, 3 итгэл үзүүлсэн, 7 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын 12 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 2 санхүүгийн тайланд / Чингис хаан Олон улсын нисэх буудал ТӨААТҮГ, Нисэх буудлуудын удирдах газар/ “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 13,880.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3.9 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4,367.9 сая төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 9,509.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 12 зөвлөмжийг хүргүүллээ.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1. Олон жилийн насжилттай 4,119.0 сая төгрөгийн дараах авлагыг барагдуулаагүй байна. Үүнд:

- ИНЕГ-ын агентлаг болон үйлдвэрлэлийн алба 2008 онд үүссэн нийт 2,209.3 сая төгрөгийн авлага,
- 2001 онд үүссэн тооцоо нийлсэн актгүй, агаарын тээвэрлэгчдийн навигацийн үйлчилгээний орлогын 1,909.7 сая төгрөгийн авлага.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдэлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх.

2. Иргэний нисэхийн салбарын мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэдэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад, дотоодын их, дээд сургууль, коллеж сургалтын байгууллагад ИНЕГ-ын захиалгаар нягтлан бодогч мэргэжлээр суралцаж байгаа нэг оюутны тайлант оны 38.4 сая төгрөгийн сургалтын төлбөрийг төлсөн байна.

Энэ нь ИНЕГ-ын даргын 2019 оны А/289 дугаар тушаалаар батлагдсан "Иргэний нисэхийн чиглэлээр суралцуулах журам"-ын 4.2, 4.3-т заасан хүний нөөцийг сургаж бэлтгэх мэргэжлийн чиглэлд хамрагдаагүй мэргэжлүүдэд сургана гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх.

Залруулагдаагүй 148.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Харьяа байгууллагуудын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 9,575.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3.9 сая төгрөгийн 2 зөрчилд

төлбөрийн акт тогтоож, 210.5 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 9,361.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 10 зөвлөмжийг хүргүүллээ.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 71,070.6 сая, эцсийн үлдэгдэл 112,371.2 сая төгрөг болж, 41,300.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	37.4	18.4	(19.0)	0.01
Банканд байгаа бэлэн мөнгө	71,029.8	112,348.7	41,318.9	99.99
Замд яваа мөнгөн хөрөнгө	3.4	4.1	0.7	0.0
Дүн	71,070.6	112,371.2	41,300.6	100.0

Эх сурвалж: Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018, 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 901.0 сая төгрөг төрийн сангийн хөрөнгө оруулалтын ажлын барьцаа болон техник хяналтын харилцах дансанд, 85,125.9 сая төгрөг арилжааны банкны дансанд, 26,321.8 сая төгрөг нь арилжааны банкны гадаад валютын харилцах дансанд тус тус байршиж байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд Чингис хаан олон улсын нисэх буудлын тээврийн хэрэгсэлийн нэвтрэх цэгийн бүртгэлийн хураамж болон рестораны үйлчилгээний орлого 4.1 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

-Чингис хаан Олон улсын нисэх буудал жижиг мөнгөн кассын үйл ажиллагааны журмаар зөвшөөрөгдөөгүй, заагдсан үнийн дүнгээс давсан 9.9 сая төгрөгийн зардлыг бэлнээр зарцуулсан,
-Чингис хаан Олон улсын нисэх буудал болон Баянхонгор аймаг дахь нисэх буудлын удирдлагууд буруутай шийдвэр гаргаснаас хүндэслэлгүй халагдсан 4 ажилтанд 21.2 сая төгрөгийн нөхөн олговор, тэмдэгийн хураамжийг төсвөөс олгосон.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 56,588.5 сая, эцсийн үлдэгдэл 78,282.3 сая төгрөг болж, 21,693.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт (+), Бууралт (-)	
Ажиллагчидтай холбогдсон авлага	90.9	85.9	(5.0)	
Дансны авлага /ТӨҮГ/	41,992.9	43,823.2	1,830.3	
Татвар, НДШ-ийн авлага	4,671.6	7,083.0	2,411.4	
Зээлийн хүүгийн авлага				
Бусад авлага	9,833.1	27,290.2	17,457.1	
Зээлийн авлага				
Дүн	56,588.5	78,282.3	21,693.8	

Эх сурвалж: Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018, 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

-Чингис хаан Олон улсын нисэх буудал нь орон нутгийн нисэх буудлууд болон ИНЕГ-ын харьяа байгууллагуудтай холбоотой 93.5 сая төгрөгийн авлага, 240.1 сая төгрөгийн өглөгийг ИНЕГ-ын авлага, өглөгийн систем хоорондын тооцоогоор хааж, системийн авлагыг 140.6 сая төгрөгийн цэвэр дүнгээр нэгтгэсэн байна,

-Нисэх буудлуудын удирдах газрын санхүүгийн байдлын тайланд 27.4 сая төгрөгийн дансны авлагыг дэлгэрэнгүй журналын дүнгээс зөрүүтэй тусгасан, аж ахуйн нэгж, иргэнтэй холбоотой 753.7 сая төгрөгийн авлагыг актаар баталгаажуулаагүй,

-Чингис хаан Олон улсын нисэх буудал нь дотоодын авиа компаниудаас авах 10,810.7 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна. Үүнд:2001-2016 онд үүссэн нийт 9,026.2 сая төгрөгийн авлага нь МИАТ ТӨХК, Аэро Монголиа ХХК, Хүннү Эйр ХХК зэрэг компаниудаас авах авлагууд байна.

-Сэргээн засах амтралтын санхүүгийн тайланд тусгасан он удаан жил болсон 1.1 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй.

2.8.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 2,032.1 сая, эцсийн үлдэгдэл 1,562.5 сая төгрөг болж, сая төгрөгөөр өссөн /буурсан/ байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	1,880.5	1,300.3	(580.2)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0.6	8.7	8.1
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	147.9	253.2	105.3
Цалингийн урьдчилгаа	0.8	0.3	(0.5)
Томилолтын урьдчилгаа	2.3	0.0	(2.3)
Дүн	2,032.1	1,562.5	(469.6)

Эх сурвалж: Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018, 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2018-2019 онд үүссэн 1,562.5 сая төгрөгийн бараа ажил, үйлчилгээний урьдчилгаа төлбөрүүд байна. Тухайлбал:

- Даатгалын үйлчилгээний төлбөрт 1,300.3 сая төгрөг,
- Инженер техникийн ажилчдаар хийлгэж байгаа нислэгийн бүртгэлийн програм хангамж 253.2 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрүүд байна.

2.8.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 7,935.1 сая, эцсийн үлдэгдэл 18,937.2 сая төгрөг болж, 11,002.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	99.3	112.2	12.9
Эм, боох материал	4.8	0.0	(4.8)
Дуусаагүй үйлдвэрлэл	4.1	5.9	1.8
Бэлэн бүтээгдхүүн	61.7	62.4	0.7
Бичиг хэргийн материал	27.7	0.0	(27.7)
Аж ахуйн материал	1,162.7	1,291.1	128.4
Сэлбэг хэрэгсэл	4,452.4	15,369.7	10,917.3
Бусад хангамжийн материал	369.2	187.9	(181.3)
Түлш, шатах тослох материал	1,753.2	1,908.0	154.8
Дүн	7,935.1	18,937.2	11,002.1

Эх сурвалж: Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018, 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны тайлант оны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 11,002.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

- ТӨБЗГ-ын 2019 оны 382 дугаар тогтоолоор 9,309.2 сая төгрөгийн шинэ нисэх буудлын үйл ажиллагаанд хэрэглэгдэх бараа материалыг шилжүүлэн авсан,
- Тайлант онд нийт 1,608.1 сая төгрөгийн бараа материалыг ИНЕГ-ын дүрмийн 171.79 дүгээр зүйлд зааснаар байгууламжийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ашиглалтын 2 жилийн хэрэгцээг хангахуйц сэлбэгийн нөөцтэй байх гэж заасны дагуу нөөцөлсөнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

-Чингис хаан Олон улсын нисэх буудал нь их хэмжээгээр худалдан авч нөөцөлснөөс 15.7 сая төгрөгийн маягт хүчингүй болж үргүй зардал гаргасан, худалдан авах ажиллагааны төсөвт өртгийг хоёр хувааж төлөвлөснөөс, 50.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 4 нэр төрлийн 382.7 сая төгрөгийн бараа, бүтээгдэхүүнийг харьцуулалтын аргаар худалдан авсан байна.

2.8.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 655,887.9 сая, эцсийн үлдэгдэл 1,899,518.7 сая төгрөг болж, 1,243,630.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөг/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	124,694.2	1,058,023.1	933,328.9
Авто тээврийн хэрэгсэл	5,497.9	65,625.8	60,127.9
Машин, тоног төхөөрөмж	36,277.6	160,865.9	124,588.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	4,201.1	4,239.6	38.5
Дуусаагүй барилга, байгууламж	20,937.7	143,895.6	122,957.9
Биет бус хөрөнгө	463,903.8	464,135.7	231.9
Хойшлогдсон татварын хөрөнгө	375.6	2,733.0	2,357.4
Дүн	655,887.9	1,899,518.7	1,243,630.8

Эх сурвалж: Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018, 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд ТӨБЗГ-ын 2019 оны 382 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-өөс балансаас балансад шилжүүлэн авсан барилга, байгууламж, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, дуусаагүй барилга, байгууламж, биет бус хөрөнгө нийт 1,255,321.1 сая төгрөгийн шинэ нисэх буудлын үйл ажиллагаанд ашиглагдах хөрөнгө, харьяа байгууллагуудад балансаас балансад шилжүүлэн өгсөн 379.0 сая, акталсан 1,174.3 сая төгрөгөөр хасагдсан байна.

ТӨБЗГ-ын 2019 оны 382 дугаар тогтоолоор 9,309.2 сая төгрөгийн шинэ нисэх буудлын үйл ажиллагаанд хэрэглэгдэх бараа материалыг шилжүүлэн авсан,

Дуусаагүй барилга дансанд Завхан аймгийн Доной нисэх буудлын хөөрч, буурах хатуу хучилттай 10,595.2 сая төгрөгийн зурвасыг Улсын комисс хүлээн авсанаар хөрөнгөөр бүртгэсэнээр дуусаагүй барилга данс 10,595.2 сая төгрөгөөр буурсан.

Хойшлогдсон татварын хөрөнгө данс тайлант онд 2,357.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь санхүү, татварын тайлангийн үзүүлэлтийн зөрүүгээр үүссэн 2,265.9 сая, валютын бодит болон бодит бус ханшийн зөрүүгээр 91.5 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

-Чингис хаан Олон улсын нисэх буудал нь эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр Нисэх буудлын удирдах газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар 31.3 сая

төгрөгийн хөрөнгийг Нисэх буудлын удирдах газарт хүлээлгэж өгсөн боловч данс бүртгэлээс хасаагүй, жилийн эцэст тоолж баталгаажуулаагүй.

2.8.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 12,814.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 23,742.3 сая төгрөг болж 10,928.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт (+) Бууралт (-)	
Богоно хугацаат өр төлбөр дүн	3,689.4	13,095.6		9,406.2
Өглөг	3,659.0	13,032.8		9,373.8
Урьдчилж орсон орлого	30.4	62.8		32.4
Урт хугацаат өр төлбөр дүн	9,124.6	10,646.7		1,522.1
Хойшлогдсон татварын өглөг	0.0	2,316.4		2,316.4
Урьдчилж орсон орлого	9,124.6	8,330.3		(794.3)
Нийт дүн	12,814.0	23,742.3		10,928.3

Эх сурвалж: Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018, 2019 оны санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн тайлан

Өглөгийн данс тайлант хугацааны эцэст 13,032.8 сая төгрөг буюу урьд оноос 28.1 хувь буюу 9,373.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өглөг дансны эцсийн үлдэгдэлд татвар, НДШ-ийн өглөг 55.0 хувь буюу 7,163.0 сая төгрөг, гадаадын агаарын тээвэрлэгчдийн болон үндсэн хөрөнгийн бэлтгэхтэй холбоотой гүйцэтгэлийн баталгааны барьцаа хөрөнгө 42.3 хувь буюу 5,594.3 сая төгрөг, 2.7 хувь буюу 275.5 сая төгрөг нь байгууллага болон хувь хүнд өгөх өглөгүүд эзэлж байна.

Урьдчилж орсон орлогын дансанд Чингис хаан олон улсын нисэх буудлын байр талбай ашиглуулсны түрээсийн орлого болох 42.2 сая, бусад орон нутгийн нисэх буудлын түрээсийн орлого 20.6 сая төгрөгөөр тус тус бүртгэсэн байна.

Хойшлогдсон татварын өглөг дансанд тайлант хугацаанд 2,316.4 сая төгрөг бүртгэсэн нь санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүү 1,971.8 сая төгрөг, валютын бодит болон бодит бус ханшийн зөрүүнээс үүссэн 344.6 сая төгрөгөөр тус тус бүртгэсэн байна.

Урт хугацаат өр төлбөрт дансны өөрчлөлтөд урт хугацаат санхүүгийн түрээсийн зардлыг төлсөн 654.5 сая төгрөг, урьд онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан хөрөнгийн санхүүжилтийн орлогыг үндсэн хөрөнгийн тайлант үеийн орлогоор хүлээн зөвшөөрч бичсэн 140.0 сая төгрөгөөр тус тус бууруулсан нь нөлөөлсөн байна.

2.8.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 780,705.7 сая, эцсийн үлдэгдэл 2,086,935.2 сая төгрөг болж, 1,306,229.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Өмч /төрийн/	688,539.2	1,947,351.6	1,258,812.4	96.4

Эздийн өмчийн бусад хэсэг				
/ТӨҮГ/	33,224.6	32,964.7	(259.9)	0.0
Хуримтлагдсан үр дүн	58,941.9	106,618.9	47,677.0	3.6
Дүн	780,705.7	2,086,935.2	1,306,229.5	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018, 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төрийн өмчийн дүн 1,258.812.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны менежмент төслийн эргэлтийн болон үндсэн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2019 оны 382 дугаар тогтоолын дагуу нэмэгдүүлэн бүртгэсэн байна.

Тайлант хугацаанд тайлант үеийн үе дүн 106,818.9 сая төгрөг буюу 47,677.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

СС-ын 2018 оны 309 дүгээр тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газар /агентлаг/-ын төсвийн зарлагыг 3,128.0 сая төгрөгөөр, ЗТХС, СС-ын хамтарсан 2019 оны 294 дүгээр тушаалаар ИНЕГ-ын харьяа үйлдвэрлэлийн албадын 2019 оны нийт орлогыг 360,950.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 248,353.2 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Гүйцэтгэлээр 3,127.5 сая төгрөгийг улсын төсвөөс олгож, 380,871.5 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос нийт 383,999.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогоос 156,000.0 сая төгрөгийн навигацийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсаныг бүрэн төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 351,041.1 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 7,806.9 сая төгрөгөөр давсан нь нислэгийн тоо урьд оноос 10,369-өөр нэмэгдсэнтэй холбоотойгоор агаарын навигацийн үйлчилгээний болон буулт, хөөрөлт, зорчигч үйлчилгээний орлого нэмэгдсэн байна.

Туслах үйл ажиллагааны орлого 29,830.4 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 12,114.4 сая төгрөгөөр илүү орлого орсон нь нислэгийн тоо ихэссэнтэй холбоотой байна.

Нийт зардлын 251,481.2 сая төгрөгийн зардал батлагдсанаар төсвийн нийт зардлын гүйцэтгэл 182,910.3 сая төгрөг буюу 72.7 хувьтай байгаа нь доорх байдлаас шалтгаалсан байна. Үүнд:

- Үл хөдлөх хөрөнгийн татварыг Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төслөөс шилжүүлэн авсан барилга, байгууламжийн үл хөдлөх хөрөнгийн татварын зардлыг 2019 оны төлөвлөгөөнд тусгасан боловч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөрөнгө орлогод авах тухай тогтоол 2019 оны 10 дугаар сард гарсан тул 2019 оны 1-3 дугаар улирлын татвар төлөгдөөгүйгээс 5,330.6 сая төгрөгийн татварыг улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн,
- Газрын төлбөрийн тухай хуулийн дагуу 25,195.3 га газрын төлбөрийг улсын төсөвт бүрэн төвлөрүүлж, төлөвлөгөөг 58.4 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан,
- Тээврийн хэрэгслийн татварыг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдан авсан автомашиныг хугацаа хойшилж нийлүүлэгдсэнтэй холбоотойгоор 15.1 сая төгрөгийг улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн,
- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын болон эд хогшил, урсгал засварын зардлыг нийт 7,350.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 1,899.6 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь төлөвлөгөөг үндэслэлгүй баталсантай холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 29 төсөл, арга хэмжээнд 107,370.7 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 11 төсөл арга хэмжээнд 42,247.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

2.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Иргэний нисэхийн ерөнхий газрын дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар хойшлогдсон татварын өр, хөрөнгө оруулалтыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Иргэний нисэхийн ерөнхий газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 277 мэдээллийг хугацаанд нь, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, тендерийн ерөнхий мэдээлэл гэх мэт мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн 0.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосноос төлбөрийг бүрэн барагдуулсан, 2,554.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлага хүргүүлснээс 2,043.4 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 3,132.6 сая төгрөгийн 18 зөвлөмж өгснөөс 8 зөвлөмжийг хэрэгжүүлж, 10 зөвлөмж хэрэгжих шатанд, зөвлөмжийн хэрэгжилт 89.9 хувьтай байна.

2.13 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Иргэний нисэхийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Залруулагдаагүй 13,880.8 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 7,424.1 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул хязгаарлалттай дүгнэлт өгч байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Иргэний нисэхийн ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Гадаад сургалттай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Иргэний нисэхийн салбарын мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэдэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад, дотоодын их, дээд сургууль, коллеж сургалтын байгууллагад ИНЕГ-ын захиалгаар 2014 оноос хойш нийт 12 орны 41 сургуульд 55 оюутан суралцаж байгаа боловч тус сургуулиудтай хамтран ажиллах гэрээ байгуулаагүй, гэрчилгээжүүлээгүй байна. Энэ нь ИНЕГ-ын даргын 2019 оны А/289 дүгээр тушаалаар батлагдсан "Иргэний нисэхийн чиглэлээр суралцуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.4-т заасан "Суралцагчдын суралцах гадаадын их, дээд сургууль, коллеж, сургалтын байгууллага нь ИНЕГ-аас гэрчилгээжсэн эсвэл хамтран ажиллах гэрээтэй байна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Зөвшөөрөгдөөгүй гадаадын их, дээд сургуульд оюутан суралцуулсан байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Иргэний нисэхийн салбарын мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэдэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад, дотоодын их, дээд сургууль, коллеж сургалтын байгууллагатай гэрээ байгуулах, гэрчилгээжүүлэх арга хэмжээ авах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

3.2 Бараа материалтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

2018 онд нийлүүлсэн 148.0 сая төгрөгийн 35 тонн бараа материалыг харьяа байгууллагуудад хүлээлгэн өгөөгүйгээс данс бүртгэлд тусгаагүй, жилийн эцэст тоолж баталгаажуулаагүй байна.

3.2.2 Эрсдэл:

Бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй байх.

3.2.3 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

3.3 Шилэн данстай холбоотой асуудал:

3.3.1 Илрүүлэлт:

Тайлант онд шилэн дансанд 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.3.2 Эрсдэл:

Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь байршуулаагүй байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, цаг хугацаанд нь шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулах.

3.3.3 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

3.4 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

3.4.1 Илрүүлэлт:

Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 9,575.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь дотоод аудитын албаны ажил хангалтгүй, харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт үр нөлөөгүй байна.

ИНЕГ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д заасан Төсвийн шууд захирагч нь дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ гэсэн заалтыг баримтлан ажиллаагүй байна.

3.4.2 Эрсдэл:

Дотоод хяналт сул байгаагаас санхүүгийн сахилга бат суларч, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Дотоод аудитын алба ИНЕГ болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэх, илэрсэн алдаа, зөрчлийг барагдуулах арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	137,631,828.2	211,158,831.8
31	Мөнгөн хөрөнгө	71,070,610.8	112,371,249.2
33	Авлага	56,588,520.5	78,282,292.0
34	Урьдчилж төлсөн зардал	2,032,074.9	1,562,522.3
35	Бараа материал	7,935,074.3	18,937,220.6
360	Бусад эргэлтийн хөрөнгө	5,547.5	5,547.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	655,887,944.5	1,899,518,688.9
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.0	0.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	655,887,944.5	1,899,518,688.9
39200	Биет хөрөнгө	170,670,864.8	1,288,754,405.9
39300	Биет бус хөрөнгө	463,903,795.7	464,135,719.2
39400	Хойшлогдсон татварын хөрөнгө	375,570.7	2,732,999.1
39500	Дуусаагүй барилга	20,937,713.2	143,895,564.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	793,519,772.7	2,110,677,520.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	12,814,005.2	23,742,291.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,689,386.4	13,095,575.4
41300	Өглөг	3,659,026.3	13,032,796.6
41400	Урьдчилж орсон орлого	30,360.1	62,778.8
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,124,618.7	10,646,715.7
42229	Хойшлогдсон татварын өглөг	0.0	2,316,455.4
42242	Урьдчилж орсон орлого /ХО/	9,124,618.7	8,330,260.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	780,705,767.5	2,086,935,229.5
51	Засгийн газрын хувь оролцоо	780,705,767.5	2,086,935,229.5
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	688,539,206.9	1,947,351,547.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	33,224,636.5	32,964,733.3
51200	Хуримтлагдсан үр дүн	58,941,924.0	106,618,949.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	793,519,772.7	2,110,677,520.8

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	316,666,404.2	371,207,141.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	316,666,404.2	371,207,141.4
120	Нийтлэг татварын бус орлого	316,666,404.2	371,207,141.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.0	0.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	276,438,505.0	281,596,545.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	276,438,505.0	281,596,545.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,765,705.0	125,596,545.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	60,781,433.2	73,151,997.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,563,171.2	9,462,200.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,076,262.7	6,937,093.0
2104	Хангамж, бараа материалын зардал	6,044,275.1	5,511,098.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,354,782.6	4,261,625.0
2107	Томилолт, зочны зардал	989,191.0	1,387,268.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,956,588.9	24,885,263.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	167,672,800.0	156,000,000.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	40,227,899.1	89,610,595.4
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	13,984,270.5	13,350,194.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	53,303,463.8	33,541,411.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	908,705.8	69,419,378.8

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	394,042,866.8	398,439,439.0
120	Нийтлэг татварын бус орлого	394,042,866.8	398,439,439.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.0	0.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	366,810,097.1	349,599,996.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	366,810,097.1	349,599,996.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	366,810,097.1	349,599,996.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	56,874,738.6	68,745,677.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,244,584.6	16,070,222.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,923,287.6	7,489,054.9
2104	Хангамж, бараа материалын зардал	7,077,184.1	12,820,531.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,011,465.8	5,076,846.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	277,678,836.3	239,397,664.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	27,232,769.6	48,839,442.0
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	2,877,535.8	3,778,042.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	9,584,801.2	11,316,846.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
2200	Дотоод эх үүсвэрээр	9,584,801.2	11,316,846.0
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-6,707,265.4	-7,538,803.6
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-15,518,653.7	0.0
14	Бусад эх үүсвэр	55,229.3	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	0.0
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	15,573,883.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	5,006,850.5	41,300,638.3
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	66,063,760.2	71,070,610.8
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	71,070,610.8	112,371,249.2

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	291,542,043.7	0.0	291,542,043.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	291,542,043.7	0.0	291,542,043.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	30,234,546.1	0.0	30,234,546.1
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	462,969,990.8	0.0	462,969,990.8
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-2,717,353.9	0.0	-2,717,353.9
Эздийн өмчийн бусад хэсэг	-147,311.5	0.0	2,990,090.3
Тайлант үеийн үр дүн	-1,176,147.7	0.0	-1,176,147.7
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	780,705,767.5	0.0	780,705,767.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	780,705,767.5	0.0	780,705,767.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,258,812,340.0	0.0	1,258,812,340.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-1,862,179.2	0.0	-1,862,179.2
Эздийн өмчийн бусад хэсэг	-259,903.1	0.0	-259,903.1
Тайлант үеийн үр дүн	49,539,204.3	0.0	49,539,204.3
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,086,935,229.5	0.0	2,086,935,229.5

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА	251,481,147.5	182,910,266.8	68,570,880.6	72.7
УРСГАЛ ЗАРДАЛ	142,721,691.5	122,914,371.1	19,807,320.3	86.1
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	117,380,364.3	104,800,221.9	12,580,142.4	89.3
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	76,923,316.8	73,151,997.5	3,771,319.3	95.1
Үндсэн ба нэмэгдэл цалин	69,410,534.8	66,320,900.7	3,089,634.1	95.5
Унаа хоолны хөнгөлөлт	5,746,905.0	5,296,766.5	450,138.5	92.2
Гэрээт ажлын цалин	1,765,877.0	1,534,330.3	231,546.7	86.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,903,927.5	9,462,200.1	441,727.4	95.5
Тэтгэврийн даатгал	6,538,481.9	6,263,127.5	275,354.4	95.8
Тэтгэмжийн даатгал	769,233.2	689,759.3	79,473.9	89.7
ҮОМШ-ийн даатгал	903,899.5	909,512.1	(5,612.6)	100.6
Ажилгүйдлийн даатгал	153,846.6	146,845.3	7,001.3	95.4
Эрүүл мэндийн даатгал	1,538,466.3	1,452,955.9	85,510.5	94.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,997,830.0	4,313,390.3	684,439.7	86.3
Гэрэл, цахилгаан	3,078,087.2	2,559,709.5	518,377.7	83.2
Түлш, халаалт	1,379,129.9	1,298,031.7	81,098.2	94.1
Цэвэр, бохир ус	300,612.9	228,542.6	72,070.3	76.0
Байрны түрээс	240,000.0	227,106.4	12,893.6	94.6
Хангамж, бараа материалын зардал	6,150,105.9	5,574,099.2	576,006.7	90.6
Бичиг хэрэг	421,477.1	325,968.3	95,508.8	77.3
Тээвэр, шатахуун	4,337,402.7	4,214,367.7	123,035.0	97.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	533,078.9	393,318.5	139,760.4	73.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	685,695.9	497,858.9	187,837.0	72.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	172,451.3	142,585.8	29,865.5	82.7
Нормативт зардал	1,119,000.0	639,897.2	479,102.8	57.2
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,119,000.0	639,897.2	479,102.8	57.2
Эд хогшил, урсгал засварын зардал	7,487,189.9	3,908,376.2	3,578,813.7	52.2
Багаж, техник, хэрэгсэл	6,961,857.3	3,423,536.7	3,538,320.7	49.2
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	525,332.6	484,839.6	40,493.0	92.3
Томилолт, зочны зардал	1,348,800.5	1,172,969.8	175,830.7	87.0
Гадаад албан томилолт	429,229.1	373,729.0	55,500.1	87.1
Дотоод албан томилолт	919,571.4	799,240.8	120,330.6	86.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,205,569.0	3,305,952.4	1,899,616.6	63.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,259,781.2	493,817.2	765,964.0	39.2
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	265,562.6	105,077.7	160,484.9	39.6
Даатгалын үйлчилгээ	2,376,830.3	1,660,587.9	716,242.4	69.9
Тээврийн хэрэгслийн татвар	41,754.5	26,217.3	15,537.2	62.8
Мэдээллийн технологийн үйлчилгээ	364,459.0	194,382.5	170,076.5	53.3
Газрын төлбөр	799,974.8	739,849.5	60,125.3	92.5

Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	54,159.2	40,207.3	13,951.9	74.2
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	43,047.4	45,813.0	(2,765.6)	106.4
Бараа үйлчилгээний бусад зардал	4,244,624.7	3,271,339.2	973,285.5	77.1
Бараа үйлчилгээний бусад зардал	1,259,954.7	1,020,829.9	239,124.8	81.0
Ном, хэвлэл	30,336.7	23,437.6	6,899.1	77.3
Түүхий эд материалын зардал	999,026.0	1,087,971.8	(88,945.8)	108.9
Хичээл үйлдвэрлэлийн дэдлага хийх	1,955,307.3	1,139,099.9	816,207.4	58.3
Мэдээлэл сурталчилгааны зардал	125,100.0	61,379.0	63,721.0	49.1
Харуул, хамгаалалтын зардал	596,212.3	483,546.0	112,666.3	81.1
Холбооны суваг ашигласны хөлс	2,609,145.1	2,505,348.9	103,796.2	96.0
Үл хөдлөх хөрөнгийн татвар	7,643,898.1	2,313,289.0	5,330,609.1	30.3
Биеийн тамирын уралдаан, тэмцээн	100,196.5	117,140.6	(16,944.1)	116.9
Сургалт семинар	450,000.0	271,787.5	178,212.5	60.4
Гадаад сургалт	330,000.0	167,621.6	162,378.4	50.8
Дотоод сургалт	120,000.0	104,165.8	15,834.2	86.8
Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	560,885.0	510,841.5	50,043.5	91.1
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	628,842.7	192,463.3	436,379.4	30.6
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	5,740,093.5	5,611,448.0	128,645.5	97.8
Орон байраар хангах, орон сууцны дэмжлэг	1,461,802.0	1,452,000.0	9,802.0	99.3
Эмчилгээний төлбөр	193,000.0	214,670.1	(21,670.1)	111.2
Олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах	612,100.0	241,000.3	371,099.7	39.4
Төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ	500,000.0	228,582.4	271,417.6	45.7
Гадаад суралцагсдын зардал	3,025,000.0	2,363,481.6	661,518.4	78.1
Нүүлгэн шилжүүлэх зардал /Шинэ нисэх буудал руу/	633,993.0		633,993.0	-
Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	461,059.0	461,059.0	-	100.0
Валютын ханшийн бодит, бодит бус зардал	-	1,086,112.2	(1,086,112.2)	
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЗЭЭЛ	1,388,722.0	1,388,722.0	-	100.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ЗАРДАЛ	107,370,734.0	42,247,670.0	65,123,064.0	39.3
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	364,078,224.0	383,999,045.2	19,921,811.2	105.5
Улсын төсвөөс олгосон санхүүжилт	3,127,975.2	3,127,480.2	495.0	100.0
Агаарын навигацийн үйлчилгээний орлого	317,556,242.2	320,460,038.5	2,903,796.3	100.9
Буулт, хөөрөлтийн орлого	13,320,612.2	16,447,352.8	3,126,740.6	123.5
Зорчигч үйлчилгээний орлого	12,357,371.0	14,133,755.7	1,776,384.7	114.4
Бусад орлого	17,716,023.4	26,346,772.2	8,630,748.8	148.7
Валютын ханшийн бодит, бодит бус орлого		3,483,645.9	3,483,645.9	0.0
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	43,402,926.0		(43,402,926.0)	-
ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО	156,000,000.0	156,000,000.0	(0.0)	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	2,431.0	2,431.0	0.0	0.0

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.03.25	Аудитын нэр: Иргэний нисэхийн ерөнхий газар	Аудитын код: САГ-2020/11/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Иргэний нисэхийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаа с гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Олон жилийн насжилттай 4,119.0 сая төгрөгийн дараах авлагыг барагдуулаагүй байна. Үүнд: ИНЕГ-ын агентлаг болон үйлдвэрлэлийн алба 2008 онд үүссэн нийт 2,209.3 сая төгрөгийн авлага, 2001 онд үүссэн тооцоо нийлсэн актгүй, агаарын тээвэрлэгчдийн навигацийн үйлчилгээний орлогын 1,909.7 сая төгрөгийн авлага.	4,119.0	Албан шаардлага өгөх.	Нягтлан бодогч	Г.Амарзаяа
2	Иргэний нисэхийн салбарын мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэдэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад, дотоодын их, дээд сургууль, коллеж сургалтын байгууллагад ИНЕГ-ын захиалгаар нягтлан бодогч мэргэжлээр суралцаж байгаа нэг оюутны тайлант оны 38.4 сая төгрөгийн сургалтын төлбөрийг төлсөн байна.	38.4	Албан шаардлага өгөх.	ИНЕГ-н дарга, СХОГ-н дарга, Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн, Ч.Нямсүрэн, Н.Наранцэцэг
3	Иргэний нисэхийн салбарын мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэдэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад, дотоодын их, дээд сургууль, коллеж сургалтын байгууллагад ИНЕГ-ын захиалгаар 2014 оноос хойш нийт 12 орны	0.0	Зөвлөмж өгөх.	ИНЕГ-н дарга	Л.Бямбасүрэн

	41 сургуульд 55 оюутан суралцаж байгаа боловч тус сургуулиудтай хамтран ажиллах гэрээ байгуулаагүй, гэрчилгээжүүлээгүй байна.				
4	2018 онд нийлүүлсэн 148.0 сая төгрөгийн 35 тонн бараа материалыг харьяа байгууллагуудад хүлээлгэн өгөөгүйгээс данс бүртгэлд тусгаагүй, жилийн эцэст тоолж баталгаажуулаагүй байна.	148.0	Зөвлөмж өгөх.	ИНЕГ-н дарга, Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн, Н.Наранцэцэг
5	Тайлант онд шилэн дансанд 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	0.0	Зөвлөмж өгөх.	Ахлах эдийн засагч	Д.Баясгалан
6	Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 9,495.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь дотоод аудитын албаны ажил хангалтгүй, харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт үр нөлөөгүй байна.	9,575.4	Зөвлөмж өгөх.	Харьяа алба, салбарын дарга, нягтлан бодогч	Харьяа алба, салбарын дарга, нягтлан бодогч
	Дүн	13,880.8			



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2020 оны 03 дугаар сарын 25

№ 01/199

Улаанбаатар хот

САНХ 2020/11/СТА-773

┌ Сургалтын төлбөрийн тухай ─┐

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийг 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Иргэний нисэхийн салбарын мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэдэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад, дотоодын их, дээд сургууль, коллеж сургалтын байгууллагад ИНЕГ-ын захиалгаар тайлант онд нягтлан бодогч мэргэжлээр нэг оюутныг 38.4 сая төгрөгөөр суралцуулсан байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, ИНЕГ-ын даргын 2019 оны А/289 дугаар тушаалаар батлагдсан “Иргэний нисэхийн чиглэлээр суралцуулах журам”-ын 4.2, 4.3-т заасан хүний нөөцийг сургаж бэлтгэх мэргэжлийн чиглэлд хамрагдаагүй мэргэжлүүдэд сургана гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Цаашид ИНЕГ-ын даргын 2019 оны А/289 дугаар тушаалаар батлагдсан “Иргэний нисэхийн чиглэлээр суралцуулах журам”-ыг баримтлан ажиллах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Ерөнхий нягтлан бодогч Н.Наранцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ	
ТОГТООСОН:	ЗӨВШӨӨРСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
 Ц.НАРАНЧИМЭГ	 Л.БЯМБАСҮРЭН
АХЛАХ АУДИТОР	ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
 Р.ЦОЛМОН	 Н.НАРАНЦЭЦЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2020 оны 03 дугаар сарын 25

№ 01/200

Улаанбаатар хот

с.т.т. 2020/11/01 СТА-ТТЗ

┌ Авлагыг барагдуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийг 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Олон жилийн насжилттай 4,119.0 сая төгрөгийн дараах авлагыг барагдуулаагүй байна. Үүнд:

- ИНЕГ-ын агентлаг болон үйлдвэрлэлийн алба 2008 онд үүссэн нийт 2,209.3 сая төгрөгийн авлага,
- 2001 онд үүссэн тооцоо нийлсэн актгүй, агаарын тээвэрлэгчдийн **навигацийн** үйлчилгээний орлогын 1,909.7 сая төгрөгийн авлага.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдэлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. 4,119.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Ерөнхий нягтлан бодогч Н.Наранцэцэг нарт хариуцуулав.

<p>ТОГТООСОН: САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР <i>Ц.Наранчимэг</i> Ц.НАРАНЧИМЭГ АХЛАХ АУДИТОР <i>Р.Цолмон</i> Р.ЦОЛМОН</p>	<p>АЛБАН ШААРДЛАГЫГ ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА <i>Л.Бямбасүрэн</i> Л.БЯМБАСҮРЭН ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ <i>Н.Наранцэцэг</i> Н.НАРАНЦЭЦЭГ</p>
---	---

Акт, албан шаардлагын биелэлтийг хангагданагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines for writing.